



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2019. 11. 14 № 26

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13., 33 дугаар зүйлийн 33.1.2.-т тус тус заасан бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг Танд хандан тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын 1.4.3.-т “мал аж ахуй, газар тариалангийн гаралтай түүхий эд, байгалийн баялгийг уламжлалт болон дэвшилтэт технологиор боловсруулж, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангасан шим тэжээллэг, баталгаатай хүнсээр хүн амыг тогтвортой хангах” чиглэлийг баримтлахаар тогтоосон. Гэтэл нийт хүн амын, ялангуяа бага насны хүүхдийн хоол шим тэжээлийн дутагдалд нэрвэгдсэний улмаас эрүүл мэнд нь доройтож байгаа тухай мэдээлэл ирэх боллоо. Иймд Монгол Улсын Засгийн газраас тус ноцтой нөхцөл байдлыг арилгахад ямар арга хэмжээ авч ажиллаж байгаа талаар болон нийт хүн амыг шим тэжээллэг, баталгаатай хүнсээр тогтвортой хангах зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд ямар үр дүнд хүрсэн талаар дэлгэрэнгүй танилцуулга ирүүлнэ үү;

2. Монгол Ардын Намын 2016 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрийн 2.9.1.-т “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, нийслэл, хот суурин газрын хүн амыг эрүүл, аюулгүй, экологийн цэвэр мах, сүүгээр хангана” гэх зорилтыг дэвшүүлсэн. Тус зорилтын хүрээнд хүн амыг, ялангуяа хүүхдийг эрдэс бодис, амин дэм болон ашигтай бичил биетийг зохих хэмжээнд агуулсан сүү, цагаан идээгээр хангах, сүү, цагаан идээний хэрэглээг нь хоногийн хэрэгцээг хангасан жишиг хэмжээнд хүргэх чиглэлээр ямар ажлуудыг зохион байгуулж, ямар үр дүнд хүрсэн талаар;

3. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, дотоодын зах зээлийн нийлүүлэлтийг эрс нэмэгдүүлэх болон импортыг орлох бодлогыг хэрэгжүүлэхэд төрөөс үзүүлэх чухал дэмжлэг бол эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжиж, сүүний урамшуулал олгох явдал юм. Иймд 2020 оны Монгол Улсын нэгдсэн төсөвт хэдий хэмжээний хөрөнгийг сүүний урамшуулалд олгохоор төсөвлөж, сүү, сүүн бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэгчдэд болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч нарт тус урамшууллыг хэрхэн хуваарилах талаар дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлнэ үү.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлж, улмаар Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

A red rectangular official stamp of the State Great Khural of Mongolia. The stamp contains the text "МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН" (State Great Khural of Mongolia) in Mongolian and "MONGOLIA" in English. Below the text is the number "УУ.А031". A handwritten signature in black ink is written over the stamp.

Ж.ЭНХБАЯР

0000000123